



ФУТЗАЛЫН ДЭЭД ЛИГ 2024-2025

ЗААВАР



2024.11.11



НЭГ. НИЙТЛЭГ ҮНДЭСЛЭЛ

- 1.1 Монгол улсад футзалын спортыг олон улсын жишигт нийцүүлэн хөгжүүлэх зорилтын хүрээнд МХБХ-ны "Футзалын Дээд Лиг" /цаашид Лиг гэх/-ийг, Монголын Хөлбөмбөгийн Холбоо /цаашид МХБХ гэх/ бодлогын хүрээнд зохион байгуулахад оршино.
- 1.2 Футзалын клубуудийн үйл ажиллагааг мэргэжлийн түвшинд бэлтгэх.

ХОЁР. ЛИГИЙН ЗОХИОН БАЙГУУЛАЛТ

- 2.1 МХБХ-ны Тэмцээн зохион байгуулах хэлтэс /цаашид "ТЗБХ" гэх/ нь, Олон Улсын хөлбөмбөгийн холбоо /цаашид "FIFA" гэх/, Азийн хөлбөмбөгийн холбоо /цаашид "AFC"/, Монголын хөлбөмбөгийн холбоо /МХБХ/-ны дүрэм, журмуудыг болон бусад эрх зүйн баримт бичгүүдийг үндэслэн зохион байгуулна.
- 2.2 МХБХ-ны эрх зүйн баримт бичгүүдэд тусгагдаагүй аливаа асуудлыг FIFA болон AFC-гийн эрх зүйн баримт бичгүүдийг мөрдөнө.
- 2.3 Лигийн үргэлжлэх хугацаа /2024.12.06 - 2025.06./
- 2.4 Лиг нь эрх бүхий 10 багийн хооронд 2 тойргийн системээр нийт 90 тоглолт МХБХ-ны Футзалын Ордонд зохион байгуулагдана.
- 2.5 Лигийн бүх үйл ажиллагаа МХБХ-ны "Мэргэжлийн тэмцээн зохион байгуулах журам"-ын дагуу явагдана.
- 2.6 Лигт оролцох клуб, багийг төлөөлж зөвхөн 1 баг оролцоно.
- 2.7 Тоглолт 2 үеэр тус бүр 20 минут цэвэр цагаар, дундаа 10 минутын завсарлагаатай үргэлжилнэ.
- 2.8 Багийн бүрэлдэхүүнд нийт 25 тоглогч бүртгүүлэх боломжтой ба 4 албаны хүн байна.
- 2.9 Үүнд: Ахлах дасгалжуулагч AFC Level 2 ба түүнээс дээш, туслах дасгалжуулагч AFC Level 1 ба түүнээс дээш, хаалгачийн дасгалжуулагч AFC Футзалын хаалгачын 1-р зэрэгтэй байна, багийн менежер болон багийн эмч заавал байна. Тоглолт бүрт ахлах болон туслах дасгалжуулагчид тоглолтод оролцоно.
- 2.10 Тоглолт бүрийн өмнө багийн бүрэлдэхүүнээс 14 тоглогчийг сонгож тухайн тоглолтод оролцоно.
- 2.11 Лигт оролцох багчуудын эрхийн төлбөр 500,000₮ байна. Төлбөрийг МХБХ-ны Санхүүгийн хэлтэст лигийн эхний тойргоос өмнө дараах дансанд шилжүүлнэ.
Голомт Банк : 3015101105 Монголын Хөл Бөмбөгийн Холбоо
- 2.12 Лигт зөвхөн мэдүүлэгт тусгагдсан дасгалжуулагч, тоглогч нар оролцоно. Багийн мэдүүлэгт багтсан хүн нь зөвхөн 1 (нэг) статустай байна. МХБХ-ноос зохион байгуулсан Лигийн тоглолт бүрт, шүүгчийн шийдвэр эцсийх байна.
- 2.13 МХБХ-ны Лигийн үеэр ТЗБХ-т хандсан хүсэлт гомдлыг зөвхөн бичгээр хүлээн авна. Тоглолтын шүүлттэй холбоотой аливаа гомдлыг хүлээж авахгүй.
- 2.14 Лигийн тоглолтын үеэр сахилга эсвэл хучдастай холбоотой асуудал гарсан тохиолдолд бичлэг үзэж нөхөж шийдвэрлэх боломжтой.
- 2.15 Багчуд тоглолт эхлэхээс 60 минутын өмнө талбайд ирсэн байх шаардлагатай. Тоглолтын протоколыг тоглолт эхлэхээс 40 минутын өмнө ТЗБХ-ээс томилогдсон тоглолт зохион байгуулагчид хүлээлгэж өгнө. Мөн энэ үеэр багийн тоглогч нарын хувцас хэрэглэлийн шалгалтыг хийнэ. Протоколыг тоглолт зохион байгуулагч болон багийн ахлах дасгалжуулагч гарын үсэг зурсанаар хүчинтэйд тооцож хэвлэл мэдээлэл болон шаардлагатай бүх сүлжээнд тараагдана. Тоглолт эхэлсний дараа нэмэгдэж ирсэн тоглогчийг тоглолтонд оролцуулахгүй.
- 2.16 Тоглолтын протоколыг тогтоосон хугацаанд өглөж ирүүлээгүй улмаас тоглолт эхлэх хугацааг хойшлуулсан тохиолдолд багт сахилгын арга хэмжээ авна.
- 2.17 Лигийн нэг тоглолтод нэг багийн 5 тоглогч шар хуудсаар торгуулсан тохиолдолд тухайн багийг 100,000₮ торгох болно. Тухайн тоглолтонд 6 болон түүнээс дээш шар хуудас дарааллан авсан тоглогч тус бүрийг 20,000₮ торгоно. Шүүд улаан хуудсаар торгуулсан тоглогчийг 50,000₮ торгоно. Торгуулийг дараагийн тоглолтын өмнө МХБХ-ны Санхүүгийн хэлтэст тушаасан байна. Торгуулийг хугацаандаа төлөөгүй тохиолдолд торгуулийн дүн тоглолт болгоны тоогоор 2 дахин нэмэгдэх болно.
- 2.18 Хуудасны болон сахилгын өнжих шийтгэлүүд нь МХБХ-ны Футзалын бүх тэмцээнд хүчинтэй үйлчилнэ.

2.19

Тоглолт наймаалцах, Лигийн явцад ямар нэгэн байдлаар өөрийн багтаа ашигтайгаар нөлөөлөх үйлдэл хийх, бусад багчудын эрх ашигт ноцтойгоор халдан Лигийн зохион байгуулалтанд хүндрэл учруулсан нь нотлогдвол МХБХ-ны "Сахилгын дүрэм", "Ёс зүйн дүрэм"-ийн дагуу тус тус хариуцлага хүлээлгэнэ.

ГУРАВ. БАГИЙН АЛБАНЫ ХҮНИЙ ҮҮРЭГ БА ХАРИУЦЛАГА

- 3.1 Багийн менежер, ахлах болон туслах дасгалжуулагч, ахлагч, эмч нар нь хариуцсан чиглэлээ төлөөлөх бүрэн чадвартай байж эрх, үүргээ чухамсарласан байна.
- 3.2 Багийн менежер нь тухайн багийн мэдээлэл МХБХ-ноос өгч вуй мэдээллийг багтаа дамжуулах, багаа төлөөлөх эрх бүхий албан тушаалтан байна.
- 3.3 Багийн ахлах дасгалжуулагч нь Азийн хөлбөмбөгийн холбоо /АФС/ -ны футзалын дасгалжуулагчийн "LEVEL - 2" зэрэглэлтэй байна. Хэрвээ гадаад иргэншилтэй дасгалжуулагч бүртгүүлэх тохиолдолд дээр дурьдсан зэрэглэлтэй адил байх шаардлагатай. Дасгалжуулагчийн бүртгэлийг ТЗБХ-д мэдүүлж, дасгалжуулагчийн лицензийг Техникийн хэлтэсд шалгуулна.
- 3.4 МХБХ-нд бүртгэлтэй клуб, багийн албаны хүн болон тоглогч нь тоглолтын шүүгчийн шийдвэртэй холбоотой аливаа эсэргүүцлийг сонин хэвлэл, телевиз болон цахим орчин ашиглаж олон нийтэд цацахыг хориглох ба зөрчсөн тохиолдолд МХБХ-ны "Сахилгын дүрэм"-ийн дагуу арга хэмжээ авна.
- 3.5 Лигт оролцох дасгалжуулагч нь зөвхөн МХБХ-ны Техникийн хэлтсээс олгосон "Дасгалжуулагчийн лиценз"-тэй байж тоглолтонд оролцоно. Тус Лигт лицензтэй дасгалжуулагч байхгүй тохиолдолд тоглолт эхлэхгүй. Тоглолтыг цуцлаж эсрэг багт 6-0 техникийн хожил өгнө.
- 3.6 Техникийн бүсээс чөлөөлөгдсөний дараа дасгалжуулагч нь үзэгчийн сүүдлаас тоглолттой холбогдолтой аливаа төрлийн эсэргүүцэл (хэл ам, үйлдэл) болон бусдыг турхирсан үйлдэл гаргасан тохиолдолд тухайн албаны хүнийг МХБХ-ны "Сахилгын дүрэм"-ийн дагуу торгоно.
- 3.7 МХБХ-нд бүртгэлтэй клуб, багийн албаны хүн болон тоглогч нь үзэгчийн сүүдлаас тоглолттой холбогдолтой аливаа төрлийн эсэргүүцэл (хэл ам, үйлдэл) болон бусдыг турхирсан үйлдэл гаргасан тохиолдолд түүнийг МХБХ-ны "Сахилгын дүрэм"-ийн дагуу торгоно.
- 3.8 Хэрэв тоглолтын явцад аливаа шалтгаанаар дасгалжуулагчгүй (багийн менежер, эмчид хамаарахгүй) болсон тохиолдолд тухайн баг нь Time-Out хийх эрхгүй тоглолтыг дуусгана.
- 3.9 Дасгалжуулагч нь клубтэй хийсэн гэрээгээ ТЗБХ-т заавал бүртгүүлнэ.
- 3.10 Лигийн мэдүүлэгт мэдүүлсэн дасгалжуулагчдыг зөвхөн Техникийн хэлтсийн зөвшөөрлөөр Лигт оролцуулна.

ДӨРӨВ. БҮРТГЭЛ, ШИЛЖИЛТ ХӨДӨЛГӨӨН

- 4.1 ТЗБЖ-ын дагуу улирлын дундах шилжилт хөдөлгөөний цонх 2 дугаар сарын 01 - 28-ны 17:00 цаг хүртэл үргэлжилнэ.
- 4.2 Лигт оролцож байгаа бүх тоглогчид FIFA CONNECT системд заавал бүртгүүлнэ. Бүртгэлд ороогүй тоглогчдыг тоглолтод оролцуулахгүй.
- 4.3 Тоглогч нь МХБХ-ны Тоглогчдын шилжилт хөдөлгөөний цонх"-оор клубээс клубын хооронд шилжилт хийхдээ зөвхөн сонгосон төрөлдөө шилжинэ.
- 4.4 Лигт оролцох багийн мэдүүлгийг МХБХ-ны ТЗБХ-д **2024 оны 11 дүгээр сарын 29-ны 17:00** цагаас өмнө зөвхөн MEUULEGMFF@GMAIL.COM хаягаар явуулна. Мэдүүлэгтэй хамт Лигт оролцох эрхийн төлбөр төлсөн баримтыг хамт өгнө.
- 4.5 Албан ёсны мэдүүлгийн анкет болон бусад шаардлагатай хавсралт материалуудыг зөвхөн XLSX (EXCEL SHEET) ФОРМАТААР ЯВУУЛСАН тохиолдолд хүчинтэйд тооцно. Өөр цахим хаяг болон олон нийтийн сүлжээгээр явуулсан мэдүүлгийг хүлээж авахгүй.
- 4.6 Дээрх хугацаанаас хоцорсон мөн зохих шаардлагын дагуу явуулаагүй мэдүүлгийг авч хэлэлцэхгүй.
- 4.6 Тэмцээний мэдүүлгийг Тэмцээн зохион байгуулах хэлтсээс шалган, зөрчил илэрсэн тохиолдолд тэмцээний зөвлөгөөнөөс өмнө бүрэн арилгуулсан байна.



- 4.8 Талбай дээр тоглох гадаад тоглогчийн тоо 1 байна. Гадаад тоглогч дараах материалуудыг бүрдүүлж өгсөний үндсэн дээр ТЗБХ-ээс тоглох эрхээ авна. Үүнд:
- FIFA-гийн "Шилжилт хөдөлгөөний журам"-ын дагуу өөрийн улсын Хөлбөмбөгийн Холбооноос Монгол улсын клубт тоглож болно гэсэн албан ёсны зөвшөөрөл,
 - Монгол улсын Иргэний харьяалал, шилжилт хөдөлгөөний ерөнхий газраас тухайн тоглогч нь Монгол улсад хуулийн дагуу ажиллаж амьдрах зөвшөөрлийн бичиг,
 - Паспортын хуулбар,
 - Тухайн тоглогчийг тоглуулах клубын албан ёсны хүсэлт ба Монгол улсад байрлах албан ёсны хаяг,
 - Гэрээний нотариатаар баталгаажуулсан хуулбар,
 - TMS бүртгэл хийгдсэн байна.
- 4.9 Монгол улсын иргэн мэдүүлэгт бүртгүүлэхдээ дараах материалуудыг бүрдүүлнэ. Үүнд:
- Тоглогч тухайн клуб, багтай байгуулсан гэрээ,
- 4.10 Багийн мэдүүлгийг МХБХ-ны Лигийн зааварт заасан хугацаанд, шаардлагын хэмжээнд бүрэн бүрдүүлж, өгнө.
- 4.11 Клуб, багчуд тухайн Лигд оролцох үндсэн ба туслах хувцасны өнгийг ТЗБЖ-ын Хавсралт 3-аар ирүүлнэ.
- 4.12 Тоглогчдын эрүүл мэндийн үзлэгт хамруулсан албан бичгийг мэдүүлэгтэй хамт ТЗБЖ Хавсралт 2-ыг хавсаргаж ирүүлнэ.
- 4.13 Дараах шаардлагуудыг хангаагүй мэдүүлгийг бүртгэж авахгүй. Үүнд:
- Овог, нэр
 - Регистрийн дугаар
 - Цээж зураг /сүүлийн зургаан сарын хугацаанд авхуулсан/
 - Хувийн дугааргүй, /1 дугаарыг зөвхөн хаалгач өмсөнө, 0 дугаартай тоглогч байх боломжгүй/
 - Клубын баталгаат гарын үсэг
 - Клубын харилцах цахим хаяг
 - Холбоо барих утасны дугаар
 - Эрүүл мэндийн үзлэгт хамрагдаж эрүүл мэндийн хуудас /Хавсралт-2/
 - Дасгалжуулагч болон тоглогч нарын клубтэй хийсэн гэрээ
 - Тэмцээнд оролцох баг үндсэн /эзэн/ ба туслах /зочин/ хувцасны өнгийг хавсаргаж ирүүлнэ /Хавсралт 3/
- 4.14 Клуб, багчуд Лигийн мэдүүлгийг үнэн зөв бөглөж зөрчил гарсан тохиолдолд тухайн клуб, баг бүрэн харичуна. Клуб, багчуд Лигд оролцох эрхгүй тоглогчийг тоглолтонд орчуулсан тохиолдолд тухайн клуб, багийг Лигээс хасч өмнөх тоглолтуудын оноо, бөмбөгний тоог хүчингүйд тооцно. Мөнгөн торгуулийг давхар ноогдуулна.
- 4.15 Тоглогчдын бүртгэл, шилжилт хөдөлгөөнтэй холбогдолтой бусад асуудлуудыг МХБХ-ны зохих журмын дагуу явагдана. Аливаа шилжилт хөдөлгөөнийг зөвхөн "МХБХ-ны Тоглогчдын статус ба шилжилт хөдөлгөөний журам"-ын дагуу үйлдсэн тохиолдолд хүчинтэйд тооцно.
- 4.16 Лигт бүртгүүлж оролцсон тоглогч зөвхөн шилжилт хөдөлгөөний цонхоор шилжинэ.

ТАВ. ТЭМЦЭЭНИЙ ЗӨВЛӨГӨӨН БА ЛИГИЙН СУГАЛАА

- 5.1 Тэмцээний зөвлөгөөн нь **11 дүгээр сарын 29ш-нд 12:00** цагаас зохион байгуулагдана.
- 5.2 Тэмцээний зөвлөгөөнд клуб, багийн менежер заавал оролцох шаардлагатай. Лигтэй холбогдолтой бүх мэдээлэлийг тус зөвлөгөөнд ТЗБХ-ээс өгөх тул дараа нь Лигийн үеэр Лиг зохион байгуулалттай холбоотой асуудал гарвал хүлээн авахгүй.
- 5.3 Техникийн зөвлөгөөнд клубууд тоглогчдын болон хаалгачийн 2 ээлжийн хувцасыг заавал авчирна. Багчуд эзэн баг болон зочин багийн өмсгөлүүдээ эцэслэн шийдвэрлэсэн байна. Багчудын хувцас хэрэглэлтэй холбогдолтой бүх асуудлуудыг МХБХ-ны "Тоглогчдын хувцас хэрэглэлийн журам"-ын дагуу ТЗБХ шийдвэрлэнэ. Лигт оролцох багчудын тоглолт бүрийн хувцасны өнгийг ТЗБХ-ээс тодорхойлж эцэслэж зарлана.
- 5.4 Футзалын Лигт оролцох тоглогчид дүрмийн дагуу шаардлага хангасан өнгө, будаг гардаггүй заалны зориулалтын пүүзтэй байна. Мөн 5 дах тоглогчийн өмсгөлийг зохих шаардлагын дагуу бэлдсэн байна. Өөр төрлийн пүүзтэй тохиолдолд тоглолтод оролцуулахгүй.

ЗУРГАА. ДҮН ГАРГАЛТ

- 6.1 Дараах байдлаар хэсгийн тоглолтын дүнг гаргана.
Хэрвээ 2 ба түүнээс дээш багууд инжил оноотой болсон тохиолдолд дараах шалгуураар тодруулна:
- A. Хоорондын тоглолтын дүнгээр,
 - B. Хоорондын тоглолтын бөмбөгний зөрүүгээр,
 - C. Хоорондын тоглолтын оруулсан бөмбөгний ихээр,
 - D. Хүснэгтийн бүх тоглолтын бөмбөгний зөрүүгээр,
 - E. Хүснэгтийн бүх тоглолтын оруулсан бөмбөгний ихээр,
 - F. Багууд талбайд байвал торгуулийн цохилтоор,
 - G. FIFA FAIR PLAY оноо тодруулах зарчимаар
 - H. Шодолтоор

ДОЛОО. ЛИГИЙН ҮЕД МӨРДӨХ ЗАРЧИМ

- 7.1 Лигт оролцож буй нийт баг тоглогчид, хөлбөмбөгийн спортыг эвсэг, нөхөрсөг, шударга, сонирхолтой байлгахын төлөө "AFC FAIR PLAY" зарчмуудыг Лигийн турш мөрдөх үүрэгтэй.
- 7.2 Лигийн үеэр дасгалжуулагчид, тоглогчдын зүгээс "AFC FAIR PLAY" зарчмыг хэрхэн хэрэгжүүлж байгаад хатуу хяналт тавина.
- 7.3 Тоглолт эхлэхийн өмнө өрсөлдөгч хоёр баг зүгээс "AFC FAIR PLAY" зарчмыг баримтлан тоглохоо илэрхийлж гар барих ёслолыг заавал үйлддэгтэй нэгэн адил тоглолт дуусмагц тоглолтын үр дүнгээс үл хамааран хоёр багийн тоглогчид шүүгч нартай болон өөр хоорондоо гар барих үүрэгтэй. Тухайн тоглолтын эхлэл, төгсгөлд хөгжөөн дэмжигчдэд хүндэтгэл үзүүлнэ. Тоглолтын дараа гар барих ёслол үйлдээгүй тохиолдолд МХБХ-ны "Сахилгын дүрэм"-ийн дагуу арга хэмжээ авна.
- 7.4 Оролцогч талууд тоглолтын талбай ба түүний орчин тойронд биеэ зөв боловсон авч явна.
- 7.5 Лиг зохион байгуулалтын талаарх санал гомдлыг тоглолт дуусаад 2 цагийн дотор ТЗБХ-т бичгээр өгнө.
- 7.6 Шүүгчийн шийдвэртэй холбогдолтой аливаа асуудлыг авч хэлэлцэхгүй.
- 7.7 МХБХ-ны бүх Лигийн үед гарсан сахилга бат, ёс зүйн холбогдолтой асуудлуудыг МХБХ-ны "Сахилгын дүрэм", "Ёс зүйн дүрэм"-ээр шийдвэрлэнэ.
- 7.8 Энэ зааварт тусгагдаагүй бусад асуудлыг Мэргэжлийн ТЗБХ тухай бүрт нь шийдвэрлэнэ.



НАЙМ. ШАГНАЛ УРАМШУУЛАЛ, ЭРХИЙН ХУРААМЖ

- 8.1 Лигий эхний 3 байр эзэлсэн багт Эрхийн бичиг, Мөнгөн шагнал, Өргөмжлөл, медаль, түрүүлсэн багт "Аваргын Цом" олгоно.
- 1-р байр: Аваргын цом, алтан медаль, өргөмжлөл, батламж, 40.000.000 төгрөг.
 - 2-р байр: Мөнгөн медаль, өргөмжлөл, батламж, 35.000.000 төгрөг.
 - 3-р байр: Хүрэл медаль, өргөмжлөл, батламж, 30.000.000 төгрөг.
 - 4-р байр: Мөнгөн шагнал 20.000.000 төгрөг.
 - 5-р байр: Мөнгөн шагнал 15.000.000 төгрөг.
 - 6-р байр: Мөнгөн шагнал 12.000.000 төгрөг.
 - 7-р байр: Мөнгөн шагнал 11.000.000 төгрөг.
 - 8-р байр: Мөнгөн шагнал 10.000.000 төгрөг.
 - 9-р байр: Мөнгөн шагнал 9.000.000 төгрөг.
 - 10-р байр: Мөнгөн шагнал 8.000.000 төгрөг.
- 8.2 Лигийн шилдэг тоглогчдыг шалгаруулж, урамшуулна. Үүнд:
- Шилдэг хаалгач: цом, батламж, 500.000 мөнгөн шагнал.
 - Шилдэг тоглогч: цом, батламж, 500.000 мөнгөн шагнал.
 - Шилдэг довтлогч: цом, батламж, 500.000 мөнгөн шагнал.
 - Шилдэг шүүгч: цом, батламж, 500.000 мөнгөн шагнал.
- 8.3 Монгол улсын Хувь хүний орлогын албан татварын хуулийн дагуу нийт шагналын сангийн 5% -ийг суутган тооцож, Татварын байгууллагад шилжүүлнэ.

ЕС. ХЭВЛЭЛ МЭДЭЭЛЭЛ

- 9.1 Лигийн үеэр ажиллах хэвлэл мэдээллийн хүмүүсийг албан ёсны зөвшөөрөлтэйгээр тусгайлан зааж өгсөн газар ажиллахыг зөвшөөрнө. Багийн албан ёсны зурагчин тоглолтын үеэр зураг авах тохиолдолд, зааавал МХБХ-ны Хэвлэл мэдээллийн ажилтантай холбогдож зохих зөвшөөрөл авч тусгай майктай орно.
- 9.2 МХБХ-ны Хэвлэл мэдээллийн ажилтны шаардлагын дагуу тухайн багийн албан хүн болон тоглогчид яриа өгөх үүрэгтэй.

АРВАН. БУСАД

- 11.1 МХБХ-ны ТЗБХ-ийн эрх мэдлээс давсан асуудлыг МХБХ-ны тухайн хороодод шилжүүлнэ.
- 11.2 Лигийн журам нь дараах хавсралтуудаас бүрдэнэ. Үүнд:
- А. ТЗБЖ Хавсралт 1 Лигийн мэдүүлэг
 - В. ТЗБЖ Хавсралт 2 Эрүүл мэндийн хуудас - Вакцины гэрчилгээ.
 - С. ТЗБЖ Хавсралт 3 Хувцасны өнгө
- Жич: Бүх хавсралтуудыг МХБХ-ны албан ёсны вэб сайтаас хандаж авч болно.

ХАВСРАЛТ 1

МОНГОЛЫН ХӨЛБӨМБӨГИЙН ХОЛБОО		ЛОГО	
"....." КЛУБЫН МЭДҮҮЛЭГ.		ХУУДАС	1
ТЭМЦЭЭН	/ ТЭМЦЭЭНИЙ НЭР /		
БАГИЙН АЛБАНЫ ХҮМҮҮСИЙН МЭДҮҮЛЭГ			
	ОВОГ		Баттулга
	НЭР		Эрдэнэбат
	АЛБАН ТУШААЛ		Ахлах Дасгалжүүлэгч
	ИРГЭНШИЛ		Монгол
	УТАСНЫ ДУГААР		99984421
	ЕМАЙЛ ХАЯГ		med.ulegmff@gmail.com
	ДАСГАЛЖУУЛАХ ЗЭРЭГЛЭЛ		AFC A
СҮҮЛИЙН 3 САРД АВАХУУЛСАН ЦЭЭЖ ЗУРАГ	ОВОГ		
	НЭР		
	АЛБАН ТУШААЛ		
	ИРГЭНШИЛ		
	УТАСНЫ ДУГААР		
	ЕМАЙЛ ХАЯГ		
	ДАСГАЛЖУУЛАХ ЗЭРЭГЛЭЛ		
СҮҮЛИЙН 3 САРД АВАХУУЛСАН ЦЭЭЖ ЗУРАГ	ОВОГ		
	НЭР		
	АЛБАН ТУШААЛ		
	ИРГЭНШИЛ		
	УТАСНЫ ДУГААР		
	ЕМАЙЛ ХАЯГ		
	ДАСГАЛЖУУЛАХ ЗЭРЭГЛЭЛ		
СҮҮЛИЙН 3 САРД АВАХУУЛСАН ЦЭЭЖ ЗУРАГ	ОВОГ		
	НЭР		
	АЛБАН ТУШААЛ		
	ИРГЭНШИЛ		
	УТАСНЫ ДУГААР		
	ЕМАЙЛ ХАЯГ		
	ДАСГАЛЖУУЛАХ ЗЭРЭГЛЭЛ		
СҮҮЛИЙН 3 САРД АВАХУУЛСАН ЦЭЭЖ ЗУРАГ	ОВОГ		
	НЭР		
	АЛБАН ТУШААЛ		
	ИРГЭНШИЛ		
	УТАСНЫ ДУГААР		
	ЕМАЙЛ ХАЯГ		
	ДАСГАЛЖУУЛАХ ЗЭРЭГЛЭЛ		

Page 1



ХАВСРАЛТ 2

МОНГОЛЫН ХӨЛБӨМБӨГИЙН ХОЛБОО



№	ТОГЛОГЧИЙН НЭРС	ҮЗЛЭГТ ОРСОН ОГНОО	ЭМЧИЙН ТЭМДЭГЛЭЛ	ГЭНЭТИЙН ОСЛЫН ДААТГАЛД ХАМРАГДСАН ЭСЭХ	
				ТИЙМ	ҮГҮЙ
1					
2					
3					
4					
5					
6					
7					
8					
9					
10					
11					
12					
13					
14					
15					
16					
17					
18					
19					
20					
21					

ХАВСРАЛТ 3


МОНГОЛЫН ХӨЛБӨМБӨГИЙН ХОЛБОО

Ш/х-259, Улаанбаатар-210646. Монголын Хөлбөмбөгийн Холбооны төв.
Хан-уул дүүрэг. 15-р хороо. Улаанбаатар. Монгол Улс.
Утас: 345964-17, Факс: 345966



МОНГОЛЫН ХӨЛБӨМБӨГИЙН ХОЛБОО

"....."БАГИЙН ХУВЦАСНЫ МЭДҮҮЛЭГ.





ФУТЗАЛЫН ДЭЭД ЛИГ 2024-2025 ОНЫ УЛИРАЛЫН ЗААВАР

